

90

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН ХАМТАРСАН
ТУШААЛ, ЗАХИРАМЖ**

1998 оны 4 дүгээр
сарын 6-ны өдөр

Дугаар 484/А.68

Улаанбаатар хот

Эмнэлэг байгуулах тухай

Нэг. Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын эмзэг хэсэгт үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн эмзэг хэсгийн хүн амд эмнэлгийн тусламж үзүүлэх зорилготой "Энэрэл" эмнэлгийг 65 ортойгоор, нэгдсэн эмнэлгийн статустай байгуулж дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. "Энэрэл" эмнэлгийн захирлаар Бундангийн Болдсайханыг 1998 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс томилсугай.

Гурав. Нийслэлийн 3 дугаар амаржих газрыг энэ оны 2 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон татан буулгаж, тус амаржих газрын багаж төхөөрөмж, эд хөрөнгийг Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд, эзэмшиж байсан барилгыг "Энэрэл" эмнэлэгт тус тус шилжүүлсүгэй.

Дөрөв. Нийслэлийн 3 дугаар амаржих газрын гүйцэтгэж байсан үүргийг цаашид Эх нялхсын эрдэм шинжилгээний төвөөр гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсүгэй.

Тав. Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан 3 дугаар амаржих газрын орон тоо, төсвийг Эх нялхсын эрдэм шинжилгээний төвд 2 дугаар хавсралтын ёсоор шилжүүлэн санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-д зөвшөөрсүгэй.

Зургаа . Нийслэлийн эрүүл мэндийн газар /Ё.Тэрбиш/-д ДААЛГАХ НЬ:

1. Шинээр байгуулагдаж байгаа "Энэрэл" эмнэлгийн орон тоо, дотоод журам, төсвийг боловсруулан холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх.
2. Шинэ томилогдсон захиралтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах.
3. Татан буугдсан 3 дугаар амаржих газарт байсан эмнэлгийн багаж төхөөрөмж, эд хөрөнгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах ба ажил хүлээлцүүлэх комиссыг томилон ажиллуулах.
4. Зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан 3 дугаар амаржих газарт ажиллаж байсан эмч ажиллагсдыг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах.

Долоо . Энэ тушаал, захирамж гарсантай холбогдуулан Монгол улсын Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 1998 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/56, А/34 тоот хамтарсан тушаал, захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



 ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН

 ХАМГААЛЛЫН САЙД



 Л.ЗОРИГ



 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ


 ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР

 ХОТЫН ЗАХИРАГЧ



 Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ОАЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 1998 оны 11/06-ны
өдрийн А-84/а 68 тоот ХАМТАРСАН ТУШААЛ,
ЗАХИРАМЖИЙН хавсралт N1



**УЛААНБААТАР ХОТЫН ЭНЭРЭЛ
ЭМНЭЛГИЙН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улаанбаатар хотын буйны Энэрэл эмнэлэг нь хотын тэнэмэл хүүхдүүд, орон гэргүй, ядуу, нийгмийн эмзэг хэсэгт хамаарагдах иргэд, хүүхдүүдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлж эмчилгээ, үйлчилгээ хийх үндсэн зорилготой мэргэжлийн байгууллага юм.
2. Энэрэл эмнэлэг нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын холбогдолтой эрх зүйн акт болон энэ дүрмийг мөрдөж, холбогдох дээд байгууллагын шийдвэрийг удирдлага болгоно.
3. Энэрэл эмнэлэг нь нэгдсэн санхүүтэй байх бөгөөд санхүүжилт нь улсын төсөв, эрүүл мэндийн даатгал, олон улсын болон өөрийн орны буйны байгууллагын тусламж, дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх явцад олсон өөрийн орлогоос бүрдэнэ.

Хоёр. Энэрэл эмнэлгийн үүрэг

1. ЭМНХЯ, Нийслэлийн засаг даргын газраас тогтоосон чиглэлээр хотын тэнэмэл хүүхдүүд, орон гэргүй, ядуу, нийгмийн эмзэг хэсэгт хамаарагдах иргэдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн тусламж үнэ төлбөргүй үзүүлэх.
2. Батлагдсан төсөв, эрүүл мэндийн даатгалын сангаас авсан санхүүжилтын хүрээнд эмчилгээ, сувилгаа, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх.
3. Эмч, дунд мэргэжилтэн, ажилчидыг зөвхөн уралдаант шалгалтаар элсүүлж, дипломын дараах сургалт явуулан, 3 жил тутам мэргэжлийн шалгалт авч ажлын байран дээр нь сонгон шалгаруулалт хийж байна.

Гурав. Энэрэл эмнэлгийн зорь

1. Удирдлагын бүтэц, зохион байгуулалт, санхүү, эмнэлэг, аж ахуйн хангамж, хүн хүчний талаар биеэ даасан үйл ажиллагаа явуулах.
2. Эмч, эмнэлгийн дунд мэргэжилтэн, ажилтануудыг сонгон шалгаруулах, ажлаас чөлөөлөх, шагнаж урамшуулах, арга хэмжээ авах зэрэг асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх.
3. Өөрийн орны болон бусад орны эмнэлэг, эрдэм шинжилгээ, сургалт, буйны байгууллагуудтай тогтоосон журмын дагуу ажил төрлийн бие даасан дотоод, гадаад харилцаа тогтоож гэрээ байгуулах.

4. Хүн хүчний орон тоо, цалингийн хэмжээг төсөв хөрөнгөндөө багтаан зохих журмын дагуу тогтоож, өмч хөрөнгөө захиран зохицуулна.

5. Эрүүл мэнд, анагаах ухаан, нийгмийн халамжийн асуудлаар төр засаг, төрийн бус байгууллагад үзэл баримтлал, санал, зөвлөмж боловсруулж өргөн барих.

6. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлэл нийтлэх

7. Нийгмийн эмээг хэсэгт үнэгүй, зөвхөн даатгалын сангаас гаргасан санхүүжилтээр (10% ийг авалгүй), эмчилгээ үйлчилгээ явуулахаас гадна өвчтөн зөвхөн манай эмнэлгээр үйлчлүүлэхээр өөрөө хүссэн тохиолдолд даатгалын системээр болон ЭМНХЯ маас баталсан тарифийн дагуу төлбөрт үйлчилгээ, эмчилгээ явуулах эрхтэй.

Дөрөв. Энэрэл эмнэлгийн удирдлага

1. Энэрэл эмнэлгийг ЭМНХЯ-ны сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хамтарсан тушаал захирамжаар томилогдсон захирал удирдаж, зорилго, зорилт, үүргийг хэрэгжүүлэх ажлыг дээд байгууллагын бичигээр харуулна.

2. Энэрэл эмнэлэг нь эмчилгээ үйлчилгээ, сургалт, санхүүгийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт өгөх, эмнэлгийн үйл ажиллагааг хамтын удирдлагын зарчим дээр зохион байгуулах үүрэгтэй захирлын зөвлөлтэй байна. Захирлын зөвлөлийн гишүүдийг захирал томилж удирдана.

3. Захирлын зөвлөлийн ажиллах журмыг захирал баталж, мөрдүүлнэ.

4. Энэрэл эмнэлэг нь хуулийн этгээдийн эрх эдлэж, зохих журмын дагуу хийгдсэн тэмдэг, дардас, албан бичиг, тушаалын нүүр, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

5. Энэрэл эмнэлэг нь Монгол улсын хөдөлмөрийн хууль, энэхүү дүрмийг үндэслэсэн хөдөлмөрийн дотоод журамтай байна.

Тав. Энэрэл эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт

1. Энэрэл эмнэлэг нь Мэс засал, Хүүхэдийн өвчин, доторын өвчний гэсэн эмчилгээний үндсэн 3 тасагтай нийт 65 ортой, Амбулаторийн 9 кабинеттай нэгдсэн эмнэлгийн статустай байна. Эмнэлгийн 65 ор нь: мэс заслын 20 (үүний дотор: эмэгтэйчүүдийн 5) хагалгааны дараах ба ерөнхий сэхээний 5, хүүхдийн 20, доторын 20 (үүний дотор: яаралтай хүлээн авах-эрчимт эмчилгээний 2, халдварт өвчин арьс өнгөний 2 ор) байна.

Амбулаторийн 9 кабинет нь: Лаборатори 1, Рентген 1, ЭКГ ба Спирометр 1, Доплер-ЭхоКардиографи 1, Шүд 1, Дотор 1, Мэс засал 1, Хүүхдийн 1, Эмэгтэйчүүдийн 1.

Амбулаторид жилд 40000-45000 хүнд үйлчилж, эмнэлэгт 20000 орчим ор хоногийн эмчилгээ хийнэ.

2. Мөн эмнэлгийн дэргэд тусгай байранд тэнэмэл хүүхдүүд, гэр оронгүй болон нэн ядуу хүмүүст зориулсан хооллох ба хонох газар байх бөгөөд өдөрт 150 хүнийг хооллож, 30 хүн хонуулж байна.



МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН
 ХАМГААЛЛЫН САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ-ДАРГА
 БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
 өдрийн 844/18 тоот ХАМТАРСАН ТУШААЛ
 ЗАХИРАМЖИЙН хавсралт N2 2011

Энэрэл эмнэлэг, ЭНЭШТ -д орон тоо төсөв хувиарлалт

Орон тоо

1998 оны улсын төсөвт Эмнэлэг, үйлчилгээний орон тоо	тоо	Энэрэл эмнэлэг	ЭНЭШТ
Эмчилгээ эрхэлсэн орлогч	71	72	20
Их эмч	12	15	12
Эх баригч, бага эмч	9	1	8
Сувилагч	25	25	
Асрагч	19	22	
Эм найруулагч			
Лаборант	1	1	
Дүн бүртгэл, даатгал	1	1	
Шил угвагч	1	1	
Дезкамерч	1	1	
Патанатомич	1	1	
Угаагч	1	1	
Нярав сувилагч	1	1	
Захиргаа аж ахуйн орон тоо	18	20	
Захирал	1	1	
Нягтлан бодох	1	1	
Нярав	1	1	
Аж ахуйн дарга	1	1	
Жолооч	1	1	
Тогооч	2	2	
Хоол зөөгч	2	1	
Орчуулагч		1	
Үйдчлэгч	1	1	
Бичиг хэрэг, Бол/хүч	1	1	
Слесарь	3	3	
Бохирын слесарь	1	1	
Цахилгаанчин	1	1	
Манаач	3	4	
Дүн	89	92	20

Төсөв (мянган төг.)

	Төсөвөөс авах	Энэрэл эмнэлэг	ЭНЭШТ
Цалин 1,2 сард	19972,7		19972,7
Зарцуулсан байгаа 8 эх	2200		2200,0
баригчийн цалин үлдсэн 10 сард	3960,		3960,
12 эмчийн цалин 10 үлдсэн сард төсөвт	107119,5	80986,8	26132,7